

**ГАРЧИГ**

1.	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
2.	ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
4.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
5.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
7.	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
8.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
9.	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
10.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
11.	ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	35
12.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	41
13.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	46
14.	ДОТООД ОВООЛГОНД ШАТАЛТ ҮҮССЭН НӨХЦӨЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	46
15.	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	50
16.	“ХОТГОР” ХХК-ИЙН НҮҮРСТ ХОТГОРЫН УУРХАЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙГДЭХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТОВЧОО	53

**ХАВСРАЛТ:**

АЖ АХУЙ НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ  
АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ  
ХЯНАЛТЫН ХУУДАС

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Хотгор” ХХК нь Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших Нүүрст Хотгорийн нүүрсний ордын талбайд MV-001441, MV-014442, MV-020853 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй залгаа орших ордуудыг эзэмшиж олборлолт явуулж байна. 1963 оноос тус ордоос жилд 20.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай ил уурхай ажиллаж эхэлсэн бөгөөд 1996 онд “Хотгор” ХК, 2010 онд “Хотгор” ХХК болж өөрчлөн байгуулагдаж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байна.

“Хотгор” ХХК нь дээрхи гурван тусгай зөвшөөрөлтэй талбайн хүрээнд үлдэгдэл нөөцийг нэгтгэн тодорхойлохоор ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж тусгай зөвшөөрлийн хил хязгаар доторх геологийн нөөц нь 22.0 сая.тн, ашиглалтын нөөц нь 1.35 сая.тн нүүрс байна гэж тодорхойлсон юм.

Хотгорын нүүрсний уурхай нь Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн хэрэглэгчид болон цахилгаан станцыг нүүрсээр хангах зорилгоор уурхайгаас жилд 90.0-100.0 мян.тн нүүрс олборлож, ачилтаас үлдэж буй нунтаг нүүрсийг шигшүүрээр ангилан ялгаж орон нутагт борлуулж байна.

Өмнөх жилүүдэд ил уурхай дотор хуримтлагдсан нунтаг нүүрсний овоолгыг борлуулах зорилгоор 2013 оны 12-р сараас эхлэн ±13 мм-ийн шигшин ялгах тоног төхөөрөмж суурилуулан ажиллуулж байна.

Тус уурхай одоогийн байдлаар автотээвэртэй, дотоод овоолготой ашиглалтын системтэй ажиллаж 13 жилд 345.5 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийн, жилд 100.0 мян.тонн нүүрс олборлохоор төлөвлөж ТЭЗҮ-д тусгасан байна. Ил уурхайн ажиллах горим, ашиглалтын систем, уурхайд ажиллах техник, тоног төхөөрөмжүүд, баяжуулах технологи өөрчлөгдөөгүй болно.

Хүснэгт- 1. Төслийн ерөнхий мэдээлэл


№	Үзүүлэлтүүд	Тодорхойлолтууд
1	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Хотгор” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар	02110051150
3	Уурхайн нэр	Хотгорын нүүрсний уурхай
4	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар	Хотгорын нүүрсний орд MV-001441 , MV-014442, MV-020853
5	Ил уурхайн хүрэн дэх үйлдвэрлэлийн нөөц	22.0 сая тонн
6	Ашиглах арга ба хугацаа	Ил аргаар 13 жил
7	Ашиглалтын систем	Ил уурхай: Тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын систем
8	Хүчин чадал	Нүүрс олборлолт жилд -100.0 мян.тн Хөрс хуулалт -345.5 мян.м <sup>3</sup>

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Физик газар зүйн мужлалын хувьд:** Алтайн уулархаг их мужийн Монгол-Алтайн уулархаг мужийн Хархираагийн салбар уулсын бүсэд хамаарагдах ба Ачит нуур, Үүрэг нуурын хотгорын хооронд орших Байрамын нурууны урд бэлд оршино. Байрам нуруунаас урагшаа буюу зүүн урагшаа Ачит нуурын хотгорын зүүн хойд талаар байрлах дунд зэргийн өндөрлөгтэй уулс нь ихэвчлэн урагшаа, зүүн урагшаа сунаж тогтсон 2000-2400 м-ийн дундаж өндөртэй уулс нь шовх оройтой, огцом хэрчигдэлтэй, гуу жалгууд нь эхэндээ маш нарийхан, хавцал маягтай гол төлөв “V” хэлбэртэй, адаг руугаа өргөснө.

**Уур амьсгал:** Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай урт өвөлтэй, богино зунтай. Хамгийн хүйтэн үе нь 1-р сард  $-27.8^{\circ}\text{C}$ , хамгийн халуун үе нь 7-р сард  $+25.5^{\circ}\text{C}$  байдаг. Жилд дунджаар 100 мм тунадас унах ба ихэнх нь 7,8-р саруудад унадаг. Анхны цас 9-р сард орж нийт нутгаар 4-р сарын дунд үе хүртэл цасан бүрхүүлтэй. Халчиг болон Байрам зэрэг уулуудын оройгоор бараг 7-р сарын эх хүртэл цастай байдаг. 10-р сарын дунд үеээс газрын хөрс хөлдөж эхлэх ба хөлдөлтийн гүн 3.0 м хүрнэ. Өндөр уулсын орой, голын хөндийн эхээр (2000 м-ээс дээш өндөрт орших) мөнх цэвдгийн бүстэй бөгөөд цэвдгийн бүсийн хил 0.5-1.0 м гүнд байдаг. Жилийн дундаж харьцангуй чийгшлийн утга 63 хувь орчим, жилийн дундаж салхины хурд 2.2 м/с орчим, хаврын саруудын салхины дундаж хурд 3.1-3.6 м/с байдаг.

**Ус зүйн хувьд:** гол хагалбар нь талбайн төв хэсэгт орших Байрамын нуруу ба түүний ар, өврөөс эх авсан голууд нь Увс нуурын, Үүрэг нуурын, Ховд голын 3 томоохон ай савд багтана. Байрамын нурууны урд талаас эх авсан Байрамын хэв, Хужирт, Мөст, Шанга булаг зэрэг голууд нь Ховдын ай савд хамаарагдана. Эдгээр голуудаас томоохон нь Байрамын хөв гол юм. Энэхүү гол Байрам нуурын өврөөс эх авч 40 гаруй км урсаад Ачит нуурт цутгана. Хөндий нь “V” хэлбэртэй, 200-1500 м өргөнтэй ба адаг руугаа өргөсгөж ус нь шургана. Гольдролын өргөн 50-500 м хүрч усны гүн нь дунджаар 0.7 м, голын дэнжийн өндөр 0.2-1.2 м, заримдаа 2.0 м-т хүрнэ. Усны урсгалын хурд нь 1.0 м/сек байна. Голын хөндий адаг руугаа намгархаг болох ба голын хөндий гаралтай хайрга, хайрганцар элсэрхэг хурдсаас тогтоно. Байрамын хөв голын 1-р дэнж нилээд сайн хөгжсөн бөгөөд түүний өндөр нь 0.8-2.0м хүрэхээс гадна голын гаралтай сэвсгэр хурдаас бүрэлдэнэ. Эдгээр голууд 11-р сараас хөлдөж, 4-р сарын дундуур гэснэ.



Ордын талбай орчмын ус зүйн сүлжээ

**Хөрсөн бүрхэвч:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт байрлах Нүүрст хотгор 1441А 14442А, 20853А дугаартай ашиглалтын талбай нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Говийн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Монгол Алтайн мужийн Хархираа-Түргэний хөрсний тойрогт хамаарагдах бөгөөд энд Нөлөөлөлд их бага хэмжээтэй өртсөн Сайр чулуурхаг, элсэнцэр Хар Хүрэн хөрснүүд зонхилох талбайг эзэлнэ. Харин Өндөр уулын хэсгээр Чулуурхаг ХарХүрэн, Хүрэн хөрс, голуудын хөндий татмаар аллювийн ширэгт, хайргархаг хөрс тус тус тархсан байна.

Хөрсний шинж чанарын хувьд талбайн хэмжээнд тархсан хөрсний ялзмагийн агууламж ижил хэв шинжийн хөрсний дундаж агууламжтай ижил, ойролцоо агууламжтай байна. Тухайлбал, Нөлөөлөлд өртсөн, Сайргархаг, элсэнцэр Хархүрэн хөрсний дээжин дэх хөрсний үржил шимийн үндсэн үзүүлэлт болох ялзмагийн хэмжээг авч үзэхэд 1.615%, Нөлөөлөлд бага өртсөн, Сайр чулуурхаг, элсэнцэр ХарХүрэн хөрсний ялзмагийн агууламж 2.568%, нөлөөлөлд ороогүй Сайр чулуурхаг, элсэнцэр ХарХүрэн 2.626% буюу нөлөөлөлд орсон байдлаас хамааран хөрсний үржил шим өөр өөр байна.

Хөрсний урвалын усан орчин (рН) бүх хөрсний дээжнүүдэд 7.65-8.0 байгаа нь хүчиллэгээс сул шүлтлэг шинжтэй байх бөгөөд зарим хөрсний дээжинд карбонатын хэмжээ ихтэй буюу өнгөнөөсөө илэрч байна. Нөлөөлөлд өртсөн, Сайргархаг, элсэнцэр Хархүрэн хөрсний өнгөн дээжин дэх карбонатын агууламж 1.65% буюу нөлөөлөлд их орсон. Хөрсний давсжилт буюу цахилгаан дамжуулах чадвар (ЕС) нь нийт хөрсөнд илрээгүй.

Хөрсөн дэх шим тэжээлийн бодисууд хөдөлгөөнт фосфорын хэмжээ 100 г хөрсөнд 1.38-1.94 мг, калийн хэмжээ 10.40-15.6 мг байгаа нь дээрх төрлийн хөрс шим тэжээлийн бодисын хангамжаар хангалттай байна.

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээс үзэхэд нийт дээж авагдсан гүний давхрагад элсэн фракц (2.0-0.05 мм)-ийн хэмжээ 61.6-64.5% буюу элсэрхэг фракц зонхилж элсэнцэр механик бүрэлдхүүнтэй байна. Харин тоосон фракц (0.05-0.002 мм)-ийн хэмжээ 25.2-28.4%, хөрсний шавар фракц (0.002 мм-ээс бага)-ийн хэмжээ 8.9-10.2%-ийг эзэлж байна. Хөрсний сайр чулууны агууламж нийт үе давхаргад илэрсэн бөгөөд дунджаар 50%. Хамгийн их чулууны агууламж нийт хөрсний дунджаар авч үзвэл 20-40 см-ын буюу гүн дэх дайрга чулууны агууламж бусад үе давхаргаас харьцангуй их байна.

Монгол улсын хөрсний бохирдлуулагч бодисын стандарт (MNS5850:2008)-тай харьцуулбал ордын талбайн хөрсөнд хийсэн хөрсний хүнд металлын шинжилгээгээр хүнд металлын агууламж **СТАНДАРТ ХЭМЖЭЭНЭЭС ДАВААГҮЙ БУЮУ СТАНДАРТ** хэмжээнд байна гэдгийг илтгэж байна.

**Ургамалан бүрхэвч:** Увс аймгийн Бөхмөрөн суман дахь “Нүүрст Хотгор” орчмын нүүрсний орд газрын зориулалтаар ашиглах 150.07 га талбайд хээрийн судалгаа явуулахад ургамалжилтын хувьд талбайн зүүн хойд талаар уул толгод, ухаа гүвээтэй, дунд хэсэг нь олборлолтонд өртсөн, баруун өмнөд хэсгээрээ цөлөрхөг хээрийн тэгш хөндийн ургамалжилттай байна.

Энд Ботууль-алаг өвс-агьт, Монгол өвс-харганат, холимог сөөгт бүлгэмдэлтэй бөгөөд энд нийт 14 овог, 36 төрөл, 47 зүйл ургамал бүртгэв.

Уг бүлгэмдэлийн 10м<sup>2</sup> талбайдаа 13-18 зүйлтэй, 1м<sup>2</sup> талбайд (1м<sup>2</sup> дахь геоботаникийн бичиглэлийн аргаар, ургацыг жингийн аргаар гаргав) 6-10 зүйл ургамалтай, Хялгана, ботууль, ерхөг, дааган сүүл зэрэг үетэн ургамал ба харгана зонхилсон, доройтсон бэлчээртээ улалж, шарилж бусад хөл газрын нэг наст ургамал ургасан төрхтэй, 48.4-49.4% тусгаг бүрхэцтэй, эрүүл талбай байхгүй, уурхайн үйл ажиллагаанаас болж сулаас дунд доройтолд өртсөн талбайн ургац 5.56-2.514 ц/га байна.

Ургамлан нөмрөгийн өөрчлөлт, доройтол: Хангайн бүс нутагт уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдсэнээс болж бэлчээр газар хүний үйл ажиллагааны нөлөөгөөр талхлагдан доройтож ургамлан бүрхэвчийн бүтэц жилээс жилд өөрчлөлтөнд орсоор байна. Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS5546:2005 стандартын дагуу бэлчээрийг доройтлын зэргээр нь сул, дунд, хүчтэй доройтсон ба доройтоогүй хэвийн соргог бэлчээр гэж ангилдаг. Бид судалж буй талбайнхаа доройтлын зэргийг тогтоохдоо ургамлан нөмрөгт зонхилогч, дэд зонхилогчийн үүрэг, ерөнхий бүрхэц, халцархай газар, хад чулуу, хагдны эзлэх хувь болон ургацын хэмжээг харгалзахын зэрэгцээ олшрогч хог ургамлын эзлэх хэмжээг голлон анхаарч үзэв.

Үүнд: Сул доройтсон бэлчээр. Бэлчээрийн үндсэн бүлгэмдлийн зонхилогч, дэд зонхилогч нь үүргээ алдаагүй боловч мал иддэг ургамлын эзлэх хувь 51%-иас бага болсон, талхлагдлын заагуур ургамал шарилж, оготнын сүүл, бага хургалж, өргөст бударгана зэрэг нэг наст 3-4 зүйл ургамал ургасан бөгөөд тэдгээр нь 10-30% эзэлдэг, ургацын бууралт 20-40% байвал сул доройтсон гэж үзэв.

Дунд доройтсон бэлчээр. Зүйлийн бүрэлдэхүүний тоо мэдэгдэхүйц цөөрч ургамлын бүрхэц багасаж, зонхилогч ургамлын ариг багассан, бүрхэцэд шарилж, оготнын сүүл, бага хургалж, өргөст бударгана зэрэг олшрогч буюу талхлагдлын заагуур ургамлууд ариг ихтэй ургаж 31-50% эзэлсэн, мал иддэг ургамлын эзлэх хувь 20-50% болсон, ургацын бууралт 41-60% болсныг дунд доройтсонд хамруулав.

Хүчтэй доройтсон бэлчээр. Зүйлийн бүрэлдэхүүн эрс цөөрч тухайн бэлчээрт 4-өөс олон олшрогч ургамал давамгайлсан зонхилогч болсон, үндсэн бэлчээрийн ургамлууд нь харлаг үмхий өвс болон нэг настанд түрэгдэн үүсмэл бүлгэмдэл үүсгэсэн байвал хүчтэй доройтолд оруулахаар тооцсон боловч одоогийн байдлаар ийм зэрэглэлд доройтсон газар байхгүй байна.

Хэвийн соргог бэлчээр. Ургамлан бүлгэмдлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүтээмжид өөрчлөлт ороогүй, унаган байдлаараа байгаа бэлчээрийг хэвийн соргог бэлчээрт оруулав.

**Амьтан:** Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг Ачит нуурын хотгор нь Монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Баруун хойд Монголын тойрогт хамаарагдах бөгөөд төслийн талбай орчмын нутагт нэн ховор, ховор амьтдын зүйл харьцангуй цөөн байдаг. Энэ нутагт Монгол орны ховор тууртан амьтан болох хар сүүлтийн дэлхийн тархацын хамгийн хойд цэг нутаг байдгаараа онцлог юм.

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг судалгааны талбай орчмын нутагт шавьж идэштэн 4, сарьсан далавчтан 5, туулай хэлбэртэн 3, мэрэгчтэн 18, мах идэштэн 10, туруутан 1 зүйл нийт 41 зүйлийн хөхтнийг бүртгэн тэмдэглэсэн байна.

Мөн тус хайгуулын талбайн орчимд 4 зүйл мөлхөгчид тархан амьдрах боломжтой бөгөөд тэдгээрээс 3 зүйл нь судалгаагаар тэмдэглэгдлээ.

Мөн 11 багт хамаарах 47 зүйл шувууд тархан амьдрах боломжтойгоос судалгааны явцад 21 зүйл шувууг нүдээр үзэж тэмдэглэсэн.

Хөхтөн амьтдаас 7 зүйл нь “ховор”, 20 зүйл нь “элбэг” зүйлийн тоонд орсон байна. Тус нутагт тархан амьдрах боломжтой шувуудаас CITES-ийн Конвенцийн I хавсралтад 4 зүйл, II хавсралтад 8 зүйл, CMS-ийн хавсралтад 10 зүйл, Азийн “Улаан ном”-д 2 зүйл тус тус бүртгэгдсэн байна.

Уурхайн үйл ажиллагааны явцад техникийн дуу чимээ, тэсэлгээний ажил, бензин тосны үнэрээс болж амьтны аймгийн төлөөлөгчид дайжиж тухайн орчны биотопод өөрчлөлт орж улмаар байгалийн экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлэх болно.

Авто машинаар замбараагүй олон салаа зам гаргах нь хөрсийг эвдрэлд оруулж, ургамлан бүрхэвчийг талхлагдалд оруулах, үүний улмаас амьтны аймгийн төлөөлөгч болох мэрэгчид, шавьж, хөрсний микроорганизмууд устаж үгүй болох талтай.

Иймээс байгалийг унаган төрхөөр нь, биологийн олон янз байдлыг хэвээр нь байлгахын тулд тухайн амьтан ургамлын экологи, биологийн онцлогтой нь нягт уялдаатай авч үзэх хэрэгтэй.

Ингэхдээ дараахь хамгаалалтын үйл ажиллагаануудыг байгаль хамгаалах ажилд хэрэгжүүлэх нь зүйтэй.

Үүнд:

Амьтадыг үргээхээс сэргийлэх үйлдвэрлэлийн дуу чимээг намсгах зорилгоор битүү хаалттай хамгаалалтын байгууламжийг хийх. Энэ нь тоосны тархалтаас мөн адил хамгаална.

Зарим төрлийн амьтны өсгөх үржүүлэхтэй холбогдсон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зохион явуулж буй сум, аймгийн болон холбогдох байгууллагын үйл ажиллагааг дэмжих

Зарим төрлийн амьтныг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид өртөхөөс хамгаалах Химийн болон муудсан хоол хүнсний зүйл, шингэн хог хаягдлыг мал амьтан идэхээс сэргийлэх, тусгайлсан саванд хадгалах, устгах.

Шөнийн идэвхитэй амьтад уурхайн гэрэлд татагдаж хөнөөгдөх аюултай тул тусгайлсан гэрлийн хамгаалалттай байлгах талаар урьдчилан анхаарах

### **Төсөл хэрэгжиж буй нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил**

**Увс аймгийн Бөхмөрөн сум.** Тус сум нь УБ хотоос 1485 км, аймгийн төвөөс 140км зайд оршдог нийт 383172.48 га нутаг дэвсгэртэй, 2209 хүн амтай, 512 өрхтэй, Гурван жигэртэй, Хар-Алтад, Байшинт гэсэн 3 багтайгаас төслийн талбай Хар-Алтад багийн нутагт хамрагдаж байна. Багуудын газар нутгийн хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт- 2. Багуудын эзлэх газрын хэмжээ, эзлэх хувь



Д/д	Багийн нэр	Талбайн хэмжээ /га/	Хилийн урт	Эзлэх хувь
1	Гурван жигэртэй	151405.41	191.56	39.51
2	Хар-Алтад	198758.53	210.24	51.87
3	Байшинт	33008.55	106.56	8.61
	Нийт	383172.48	332.08	100.00

**Хар-Алтад багийн товч танилцуулга:** Хар-Алтад баг нийт 198758.53 га талбай, 764 хүн ам, 50601 тоо толгой малтай. Тус багийн зүүн хэсэгт Хархираа Түргэний уулс сүндэрлэдэг. Түрэг уул нь Байгалийн үзэсгэлэнт газар бол Бумбын Гозгор уул нь 3748 метрийн өндөтэй мөнх цаст уул юм. Мөн Олон нуур, Ямаатын гол байна. Мөн Нүүрст хотгор, Шанага, Хотгор, Шанд зэрэг нүүрсний уурхайтай.

Нийт сумын нутаг дэвсгэрийн 81.08% буюу 310667.1 га нь хөдөө аж ахуйн газар, 3.59% хувь буюу 13758.95 га нь хот тосгон бусад суурины газар, 0.56% буюу 2136.757 га нь зам, шугам сүлжээний газар, 4.6 % буюу 17619.77 га нь усны сан бүхий газар, 9.94 % буюу 38098.18 га нь улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлж байна.

Сумын бэлчээрийн даацыг баг тус бүрээр авч үзвэл Хар-Алтад баг 194961.4 га буюу 54%-ийг, Гурван жигэртэй баг 151235.8 га буюу 42%-ийг, Байшинт баг хамгийн бага буюу 16620.97 га буюу 4%-ийг тус тус эзлэж байна

Хотгор тосгон нь тус уурхайг түшиглэн байгуулагдсан бөгөөд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 7-р багт харьяалагддаг. Тус уурхайд ажиллаж байсан ахмадуудад жил бүр 2 тн нүүрс үнэгүй олгодог. Тосгоны хүн эмнэлгийн салбарт дэмжлэг үзүүлж нүүрсийг хөнгөлттэй үнээр олгодог болно. Тус уурхай нь Бөхмөрөн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдагтай уялдуулан компанийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд сумын удирлагатай жил бүр хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажилладаг. Сумын өрх бүрт жилд бүр 2 тонн нүүрс олгодог. Нүүрсний агаарын бохирдлын төлбөр, нөөц ашигласны төлбөр, газрын болон ус ашигласны төлбөр, цалингийн ашгийн татварыг аймаг, суманд төлж, эдийн засгийн дэмжлэг үзүүлдэг.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1 Агаарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 3. Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Шатах тослох материалыг ил задгай байлгах, асгарч алдагдсанаас агаарт уурших, хорт бодис үүсэх, салхины нөлөөгөөр тархах зэргээр агаарын чанар, найрлагыг өөрчлөх				+
Хог хаягдлыг шатааж устгах нөхцөлд хортой хий ялгарч, агаарын бохирдол үүсгэх		+		
Болзошгүй аюул ослын үед хорт хий ялгарч, агаарын чанарт нөлөөлөх		+		
Нүүрс олборлох, тээвэрлэх, ачих, буулгах үед агаарт тоосжилт үүсэх			+	
Уурхайн дотоод, гадаад замаас үүсэх тоосжилт агаарын чанарт нөлөөлөх			+	
Дизел станц ажиллуулах, шатах тослох материалын агуулах, автомашин болон хүнд даацын машин механизмыг шатахуунаар цэнэглэх зэрэг үйл ажиллагааны үед агаарт ууршилт үүсэх			+	
Уурхайн олборлолтын үйл ажиллагааны туршид ашиглагдах тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмуудаас нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрстөрөгчийн давхар исэл (CO <sub>2</sub> ), азотын ислүүд (NO <sub>x</sub> ), хүхрийн ислүүд (SO <sub>x</sub> ) болон тоосжилт ялгарч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх			+	
Цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох			+	
Өрөмдөх тэслэгээний ажлын үед агаар орчин түр хугацаагаар бохирдох			+	
Агаарт учруулж болзошгүй нийт нөлөөллийн 28.57 хувь нь “бага”, 57.14 хувь нь “дунд”, 14.29 хувь нь “их” нөлөөлөлтэй байгаа тул агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийн үр дагаврыг “дунд” зэрэг гэж үзэж болно.				

#### 3.2. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Нүүрс олборлох явцад хөрсний эвдрэл үүсэх				+
Нүүрс ачих, буулгах, тээвэрлэх явцад хөрс эвдрэх			+	
Уурхайн дотоод, гадаад зам үүсгэснээр хөрс эвдрэх				+



Шатах тослох материалыг хадгалах, түгээх, тээвэрлэх үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу явуулаагүйгээс нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд алдагдах, хөрсний бохирдол үүсгэх				+
Хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдсанаас хүн, амьтан, ургамал, гадаргын болон газар доорх усанд дам нөлөөлөл учруулах			+	
Ажиллагсдын тосгон байгуулах явцад хөрсний эвдрэл үүсэх			+	
Хөрсний шимт бодисын нөөц хомсдох				
Хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх				
Олборлолтын явцад гарах хурдас чулуулгаар эрүүл хөрс дарагдаж дагтарших				
Ухсан газарт ландшафтын эвдрэл үүсч, хөрсний генетик үе давхаргууд холилдон морфологи тогтоц бүрмөсөн алдагдах				
Газрын гүн дэх хурдас чулуулаг ил гарч, хөрсний масс холилдох				
Хөрс салхинд хийсч элэгдэж эвдрэх үйл явц нь ихсэн тоосжилт нэмэгдэх				
Хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсэх				
Ахуйн бохир ус, хатуу хог хаягдлаар хөрс бохирдох			+	
Хөрсөнд учруулж болзошгүй нөлөөллийг үнэлж үзэхэд 12.50 хувь нь “бага”, 50.00 хувь нь “дунд”, 12.50 хувь “их”, 25.00 хувь нь “хүчтэй” нөлөөлөлтэй байгаа тул уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг үр дагаврыг “дунд” зэрэг гэж үзэж болно.				

### 3.3. Гадаргын болон газрын доорх усанд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

#### Хүснэгт- 5. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Нүүрсний уурхайн технологид ус ашигласнаас гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах, хомсдуулах	+			
Нүүрс олборлолтоос гадаргын болон газрын доорх усны нөөцийг хомсдуулах, бохирдуулах	+			
Шатах тослох материал асгарч алдагдсанаас хур борооны усаар дамжин бага гүнд орших газрын доорх усыг бохирдуулах		+		
Унд-ахуйн хэрэгцээнд ус ашигласнаас усны нөөц, горим, чанарт сөрөг нөлөөлөл учруулах		+		
Ахуйгаас гарч буй хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах		+		
Гадаргын болон газрын доорх усанд учруулж болзошгүй нөлөөллийг үнэлж үзэхэд 40.00 хувь нь нөлөөлөлгүй, 60.00 нь “бага” нөлөөлөлтэй байгаа тул уурхайн үйл ажиллагаанаас усны нөөцөд учруулах сөрөг нөлөөллийн үр дагаврыг “бага” гэж үзэж болно.				

3.4. Ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 6. Ургамалан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Нүүрс олборлох явцад хөрс хуулалт хийснээс ургамалан нөмрөгийг гэмтээх, устгах			+	+
Нүүрс ачих, буулгах, тээвэрлэх явцад ургамалан нөмрөгийг гэмтээх, устгах			+	+
Уурхай орчмын хөрсийг онгилон ухах үед зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарах			+	+
Уурхай орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх			+	+
Уурхайн дотоод, гадаад зам үүсгэснээр нөмрөгийг гэмтээх, устгах			+	+
Уурхай орчмын үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устгах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох		+		+
Ургамалан нөмрөг тоосонд дарагдаж бохирдсоноос ургах чадвар нь буурах		+		+
Шатах тослох материалыг хадгалах, түгээх, тээвэрлэх үйл ажиллагааг шаардлагын дагуу явуулаагүйгээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, ургамалан нөмрөгийг гэмтээх, бохирдуулах			+	+
Нийт нөлөөллийг авч үзэхэд 25 хувь нь “бага”, 62.5 хувь “дунд”, 12.5 хувь нь “их” нөлөөлөлтэй байгаа тул уурхайн үйл ажиллагаанаас ургамалан нөмрөгт учруулах нөлөөллийг ерөнхийд нь “дунд” зэрэг гэж үзэж болно.				

3.5. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 7. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Газрын хэвлийд эвдрэл үүсэх			+	+
Ухмал карьер, талбайд овоолго үүсэх			+	+
Хөрс хуулалт ба түүний овоолгоос геологи орчин, агаар, хөрс, ус бохирдох			+	+
Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал, амьтанд аюултай байдал үүсэх		+		+
Карьерийн хажуугийн хурдас ба овоолгын тогтворжилтоос хамааран шинээр хажуугийн үйл явц үүсэх (нуралт гулсалт г.м)			+	+
Ашиглалтын улмаас уурхайн хажуу хананд зохиомол ачаалал үүсч уулын чулуулгийн үндсэн тогтоц өөрчлөгдөх		+		+
Нүүрсний нөөц хомсдох				+
Геологийн тогтоц өөрчлөгдөх				+

Нийт нөлөөллийг авч үзэхэд 25 хувь нь “бага”, 37.5 хувь “дунд”, 37.5 хувь нь “хүчтэй нөлөөлөлтэй байгаа тул уурхайн үйл ажиллагаанаас ургамалан нөмрөгт учруулах нөлөөллийг ерөнхийд нь “дунд” зэрэг гэж үзэж болно Дээрхи нөлөөллүүд газрын гадаргын байгалийн төрх, геологи орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд өөрчлөлт үүсгэж, техноген ландшафтын элементүүдийг буй болгоно.

### 3.6. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 8. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх		+		
Хөрс шүтэн амьдрагч мэрэгч амьтад, мөлхөгчид болон шавьжийн зүйлийн бүрдэл, тоо толгойг бууруулах			+	
Хөрсний эвдрэл, доройтол, орчны тоосжилт, үйлдвэрлэлийн улмаас ургамал идэшт амьтдын тоо толгой буурах		+		
Ахуйн хаягдлыг ил байршуулсан тохиолдолд хэрээ, шаазгай, элээ зэрэг хаягдал шүтэн амьдардаг синантроп шувууд цуглах		+		
Бохирдсон өвс ургамлыг мал, амьтан идэж хордох	+			
Бохирдсон ус ууснаас мал, амьтан хордох	+			
Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх		+		
Нийт нөлөөллийг авч үзэхэд 28.6 хувь нь “сөрөг нөлөөлөлгүй” 57.1 хувь нь “бага”, 14.3 хувь “дунд” нөлөөлөлтэй байгаа тул уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт учруулах нөлөөллийг “бага” гэж үзэж болно.				

### 3.7. ТХГН, түүх, соёлын дурсгалт зүйлст учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 9. ТХГН, түүх соёлын зүйлст учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Тусгай хамгаалалттай газар нутаг	+			
Түүх, соёлын дурсгалт зүйлс	+			
Нийт нөлөөлөл 100% “сөрөг нөлөөлөлгүй” гэсэн ангилалд хамаарч байгаа тул нүүрс олборлолтоос тусгай хамгаалалттай газар нутаг болон түүх, соёлын дурсгалт зүйлст учруулах “сөрөг нөлөөлөлгүй” гэж үзэж болно.				

3.8. Уур амьсгалын хүчин зүйлстэй холбоотойгоор үүсэх сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 10. Цаг уур, уур амьсгалын хүчин зүйлстэй холбоотой сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Сөрөг нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Нүүрсний уурхайгаас орчны бичил уур амьсгалд учруулах сөрөг нөлөөлөл	+			
Хэт халалтаас ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл		+		
Температурын өөрчлөлтөөс уурхайн ажлын горимд нөлөөлөх нөлөөлөл			+	
Аянга цахилгааны үйлчлэлээс үүсэх нөлөөлөл		+		
Аадар бороо, үерээс үүдэлтэйгээр үүсэх сөрөг нөлөөлөл		+		
Хүчтэй салхи, шуурганаас үүсэх нөлөөлөл			+	
Болзошгүй нөлөөллийн 50.0 хувь нь “бага”, 33.3 хувь нь “дунд”, 16.7 хувь нь нөлөөлөлгүй байгаа тул цаг уур, уур амьсгалын хүчин зүйлстэй холбоотойгоор үүсэх нөлөөллийн үр дагаврыг “бага” гэж үзэж болно.				

3.9 Нийгэмд учруулж болзошгүй эерэг,сөрөг нөлөөлөл

Хүснэгт- 11. Нийгэмд учруулж болзошгүй эерэг,сөрөг нөлөөлөл

Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийн үр дагавар			
	Маш бага	Бага	Дунд	Их
Төсөл хэрэгжисэнээр улсын төсвийн орлого нэмэгдэх			+	
Орон нутагт ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх		-		
Төсөл хэрэгжисэнээр шинээр ажлын байр нэмэгдэх			+	
Төсөл хэрэгжисэнээр тухайн орчинд оршин суугаа хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	0			
Тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын зарим хэсгийг нүүлгэн шилжүүлэх шаардлага гарах	0			
Төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйлс өртөх	0			
Орон нутгийн иргэдийн байгалийн дагалт баялаг (самар жимс түүх, мод түлээ бэлтгэх г.м)-ийн ашиглалт, малчдын бэлчээр ашиглалт, оторлолт, ус ашиглалтад нөлөөлөх		+		
Шинээр бий болох ажлын байранд олон хүмүүс ирж ажилласнаас халдварт өвчин (сүрьеэ, амьсгалын замын болон бэлгийн замын халдварт өвчин г.м) нэмэгдэх		+		
Төслийн талбай нь малын бэлчээр болон иргэдийн амьдрах суурьшлын бүстэй давхцаж, зөрчил маргаан үүсгэх	0			
Аюулгүй ажиллагааны дүрэм, горимыг зөрчсөнөөс ажлын байранд осол, гэмтэл гарах		-		
Тодорхой мэргэжилтэй хүмүүсийн ажлын байр нэмэгдэх (харуул хамгаалалт, эмнэлэг, засвар, үйлчилгээ г.м)			+	

Хэт халуун, хүйтэн, дуу шуугиан, тоосжилт бүхий ажлын байранд ажиллах хүмүүс мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөх		-		
Уул уурхайн салбарт боловсон хүчин бэлтгэх сургалтын боломж хязгаарлагдмал нөхцөлд орон нутгийн ажилгүйчүүдийн ажилд орох хүлээлт, бүхимдал, зөрчил үүсэх		-		
Орон нутгийн иргэд үйлдвэр болон уурхайн ажлын байранд тэнцэхгүй, мэргэжил, туршлага дутмаг гэх шалтгаанаар бусад газраас ажилчдыг олноор авч ажиллуулснаар тэдний хооронд зөрчил үүсэх		-		
Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулснаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх		-		
Орон нутагт амьдарч буй эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах		+		
Тэсрэх бодис, химийн хорт бодис зэрэгтэй зүй бус харьцсанаас ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учруулах		-		
Төсөл хэрэгжсэнээр эмзэг, нөлөөлөлд хялбар өртөмхий хүмүүст (эмэгтэйчүүд, өндөр настнууд, хүүхэд, бага орлоготой хүмүүс) нөлөөлөх	0			
Орон нутгийн иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүүхэд залуучуудад боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх		+		
Орон нутгийн иргэдийн эрхэлж буй жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх		+		
Орон нутгийн бизнесийн болон дэд бүтцийн үйлчилгээ нэмэгдэхтэй холбогдуулан шинээр ажлын байр бий болох				
Болзошгүй нөлөөллийн 81,3.0 хувь нь “бага” нөлөөлөлтэйгээс 53.9 хувь нь сөрөг, 46.1 хувь нь эерэг 18.7 хувь нь “дунд” эерэг нөлөөлөлтэй учир үр дагаврыг “эерэг” гэж үзэж болно.				

#### **4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

##### **4.1. Эрхзүйн үндэслэл ба гол шаардлага**

Шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар уул уурхайн олборлолт, баяжуулалтын төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч “Хотгор” ХХК-д ноогдсон.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 аргачлал аргагүйг баримтлан боловсрууллаа.

“Хотгор” ХХК нь Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн хэлтсээр батлуулсан 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулна.

2018 оны 04-р сарын 18-ны өдрийн Т/18-0303 тоот Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтэд MV-020853, MV-001441, MV-014442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Хотгорын нүүрсний ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-д тусгаснаар 2024 онд 189.5 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 100.0 мян.тн нүүрс олборлолтын ажил хийгдэнэ.

Тус уурхай нь нүүрсийг тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлж олборлоно. Урьд онуудад хуримтлагдсан болон олборлосон нүүрсийг ачилт хийгдэсний дараа үлдэх 50-70 мян.тн нунтаг нүүрсийг 25 мм \* 25 мм нүхний хэмжээтэй чичиргээт шигшүүрээр ангилан ялгаж баяжуулаад 30 мян.тн нүүрс бэлтгэж, орон нутгийн хэрэглэгч нарт борлуулахаар төлөвлөж байна.

Нүүрсийг дотоодын зах зээлд буюу Баян-Өлгий аймгийн хэрэглэгчдийг 100%, Ховд аймгийн хэрэглэгчдийн 10-15 %-ийг, Увс аймгийн ойрын сумуудын аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч нарыг нүүрсээр хангаж ажиллана. Хэрэглэгч нар нь нүүрсийг уурхайн амнаас шууд худалдан авч, өөрсдийн тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Гадаад тээврийн ажил хийгдэхгүй.

Нүүрс борлуулах үнийг орон нутгийн дотоодын зах зээлд одоо борлуулж байгаа ойролцоо орших нүүрсний уурхайнуудын борлуулалтын дундаж үнээр буюу 1 тонн бүхэл нүүрсийг 62.0 мян. төг, 1 тонн шигшүүрийн нүүрсийг 60.0 мян. төгрөгөөр /НӨАТ орсон үнэ/ борлуулахаар төлөвлөгөөнд тусгав.

2024 онд 6 140 000.0 мян.төг-ийн борлуулалтын ажил хийж, улсын ба орон нутгийн төсөвт 954540.0.0 мян.төг-ийн орлого оруулахаар төлөвлөсөн байна.

2024 онд 0.87 га талбай уулын ажилд хамаарах ба 0.80 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгдэнэ.



## **5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **5.1. Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ**

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед болон овоолго, уурхайн догол, мөрөгцөгүүд, автотээврийн зам, өрөмдлөг, тэсэлгээ зэргээс салхины үйлчлэлээр сул тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг. Хавар, зун, намрын хуурайшилттай үед тоосжилт бууруулах арга хэмжээ авах зорилгоор талбайг усаар усалж, чийглэж бууруулах шаардлагатай.

**Бууруулах, арилгах арга зам:** Уурхайн дотоод тээврийн зам, ухлагад өртсөн талбайг хуурайшилт ихтэй үед тогтмол усалж тоосыг нь дарах, тоосжилт өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилчдыг тусгай хамгаалах хэрэгслээр хангаж ажиллана. Мөн доорх арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

#### **Утгуурт ачигч болон Экскаваторын ажлын үед:**

- Ажлын талбай болон мөргөцөгийг чийглэх
- Кабиныг битүүмжилж тоос шүүх агааржуулагч төхөөрөмжөөр тоноглох
- Кабиныг чийгтэй алчуураар цэвэрлэж байх

#### **Авто зам:**

- Дулааны хуурайшилттай үед уурхайн замыг услах, чийглэх
- Олон салаа зам гаргахгүй байх
- Тэмдэг тэмдэглэгээг зохих газарт байрлуулах

#### **Овоолго:**

- Хөрс хуулалтаас гарч буй хөрс, чулууллагыг олборлолтонд өртсөн хоосон талбайд дүүргэлт хийж, дотоод овоолго байгуулна.

#### **Хорт хийг бууруулах**

Хүнд машин, механизмуудын дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа болон хорт хийн хэмжээг оношлуулж, хэрвээ стандарт хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд янданд шүүлтүүр тавих замаар багасгах арга хэмжээ авна.

#### **Агаар орчны шинжилгээ**

Агаар орчны шинжилгээг аймгийн УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2 удаа хийлгэнэ.



Хүснэгт- 12. Агаар орчны бохирдолыг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9
Олборлолтод өртсөн газар, дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Олборлолтод өртсөн газар, дотоод тээврийн замыг чийглэх	Уурхайн хэмжээнд	тн	-	-	3500.0	2024 оны 5,6,7, 8, 9 сарууд	Агаарын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2010-05) 18 дугаар зүйл Усны тухай хууль (2012) 32.8 дугаар зүйл
Тоосжилт үүсэх газарт ажиллаж байгаа хүмүүс	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хошуувч, амны маск авч өгөх	Босоо амын хажууд болон ачиж буулгах талбай	ш	1300	1000	1300.0	2024 онд	Агаарын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2012) Хөдөлмөр хамгааллын систем.
Хэт хуурайшилттай үед үүсэх тоос	Хэт их салхитай үед нүүрс тээврлэлтийг зогсоох	Ил уурхайд		Шууд тооцох боломжгүй	Шууд тооцох боломжгүй	-	2024 онд	MNS 4596:2007, замын тэмдэг,

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9
Ил уурхай дотор тэсэлгээ хийх үед	Тэсэлгээ хийх үед усан дэр ашиглах							тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм Агаарын тухай хууль (Шинэчилсэн найруулга, 2012)  MNS 5013 :2001 Усны тухай хууль, 5-р бүлэг, 32.8
<b>Дүн</b>						<b>4800.0</b>		

## 5.2. Усан орчин хамгаалах арга хэмжээ

Олборлолтын явцад шатах тослох материалын асгаралт, ахуйн бохир усны нэвчилт зэргийн нөлөөгөөр орд орчмын хөрсний болон гүний ус бохирдох зэргээр усны чанар, нөөцөд сөрөг нөлөө учруулж болзошгүй.

Нөлөөлөлд өртөх объект:

Газрын доорхи ус

Хүн ам, ургамал

- Усны шинжилгээг аймгийн УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 2 удаа хийлгэнэ.
- Ажиллагсдын унд, ахуйн хэрэглээний зориулалтаар хэрэглэж буй Ямаатын гол, цаг агаарын хуурайшилттай үед уурхайн зам, талбайг чийглэх зорилгоор ашиглаж буй Байрны голын уснаас тус тус шинжилгээ авна.

Хүснэгт- 13. Усан орчны бохирдолыг бууруулах, хянах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9
Усны эх үүсвэрийг болзошгүй бохирдолоос хамгаалах	Байрны голын сайр дагуу хогийг цэвэрлэх, зайлуулах	-				600.0	2024 он	Усны тухай хууль, 21 дүгээр зүйл  MNS 4628: 1998 Шатахуун түгээх станц. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага. Монгол Улсын Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Усан орчинд хүний үйл ажиллагаанаас үүдэх сөрөг нөлөөлөл	Уурхай дотор болон уурхайн ойр орчим хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн					180.0		



Нүүрст Хотгорын уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9
	бүтээгдэхүүн хаяхгүй байх /урьдчилан сэргийлэх арга хэмжээ/.Хаягдсан тохиолдолд цэвэрлэх							
	Уурхайн гүн ухлагтай хэсэгт хүн, мал, амьтан унаж осолдохоос сэргийлж анхааруулах тэмдэг тавих.	уурхай	шир	70 000	3	210.0	2024 он	
<b>Нийт дүн</b>						<b>990.0</b>		

### 5.3. Хөрс, ургамал хамгаалах арга хэмжээ

Уурхайн олборлолтод өртсөн газрын хөрс, геологийн тогтоцын эвдрэл, машин механизмын хөдөлгөөний улмаас элэгдэлд орж тоосжилт үүсэх болон машин механизмын яндангаас хаягдах хорт хий, хүнд металл зэргээр орчны хөрс, ургамал бохирдох. Үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт хяналт шинжилгээний бүртгэл, тайланг эрх бүхий байгууллагаас баталсан маягтаар гаргана.

- Хөрсний шинжилгээг аймгийн УЦУОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 1 удаа хийлгэнэ.
- Техникийн нөхөн сэргээлтийг зохих хууль, журам зааврын дагуу гүйцэтгэнэ.
- Цаг агаарын хуурайшилттай үед уурхайн ажлын дотоод зам, талбайг усаар чийглэж, зарцуулсан усны бүртгэл хөтлөнө.
- Олон салаа зам гаргахгүй байх, тээврийн хэрэгслийг зөвхөн нэг замаар зорчуулах зорилгоор 2015 онд нэг зам төслийн хүрээнд хийгдсэн 18 км замын 2 талд ухаж татсан шуудууг сэргээж цэвэрлэнэ.
- Дотоод замын тэмдэг, тэмдэглэгээ хийнэ.
- Шимт хөрсийг тусад нь овоолно.
- Уурхайн шимт хөрсний талбайг хуурай, салхи ихтэй үед усалж байна.

Хүснэгт- 14. Хөрс, ургамал, амьтан хамгаалах зардал

Нүүрст Хотгорын уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9
Амьтадын амьдрах, үржих орчинг сайжруулах	Уурхайн орчимд 1.5 х 1.5 х 1.5м хэмжээтэй чулуун хоргыг барьж байгуулах	Уурхайгаас 2500-3000 м зайд	ш	80 000	3	240.0	2024 онд	MNS:3297:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ.
Хөрс, ургамал хамгаалах	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг шинэчлэн сайжруулах	Тээврийн хэрэгслийн зам талбай	ш	70 000	4	280.0	2024 онд	

	Олон салаа зам гаргахгүй байх, тээврийн хэрэгслийг зөвхөн нэг замаар зорчуулах зорилгоор 2015 онд <b>Нэг зам</b> төслийн хүрээнд хийгдсэн замын 2 талд ухаж татсан шуудууг сэргээх, цэвэрлэх, шуудууг сэтэлж зам гаргасан тохиолдолд ухаж сэргээх		км	150000	8	1200.0	2024 онд	NS:2305:1994 Хөрсний дээж авах, савлах, тээвэрлэх хадгалах журам
	Борооны ус үерийн хамгаалалтын шуудууг сэргээж цэвэрлэх	Уурхай	м	360	2278	810.0	2024 онд	
	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн аманд болон эзэмшил газарт тарьсан модыг арчлах, услах	Эдэлбэр, эзэмшил газар	га		0.25	1600.0	2024 онд	

Нүүрст Хотгорын уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Шимт хөрсний овоолго байгуулах, хамгаалах	Уурхайн хөрс хуулалтын үед гарах шимт хөрс		м <sup>3</sup>	880	2500	Үйлдвэрлэлийн зардалд орсон	2024 онд	
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн аманд, эзэмшил газарт 900 ширхэг бургас мод тарьж, арчлан хамгаалж ургуулна.			га	0.20		2024 оны уулын ажлын төлөвлөгөөний үйлдвэрлэлийн зардалд оруулсан болно.	2024 онд	



Нүүрст Хотгорын уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Бөхмөрөн сумын нутаг дэвсгэрт хамаарах агнуурын бүс нутгуудад биотехникийн арга хэмжээ авна			-	-	2024 оны уулын ажлын төлөвлөгөөний үйлдвэрлэлийн зардалд оруулсан болно.	2024 онд	
<b>Нийт дүн</b>					<b>4130.0</b>		

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын уул-геологийн нөхцөл, ордыг ашиглах технологи зэргийг үндэслэн өмнөх ашиглалтын жилүүдэд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж ирсэн. Ашиглалтын явцад олборлолтод өртөж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байна.

MV-001441 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ил уурхайн талбайгаас гарах хөрсийг MV-001441 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн өмнөх онуудын ашиглалтаар үүссэн ухашид нөхөн дүүргэлтээр дотоод овоолго байгуулна.

MV-014442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаас гарах шороо, чулуулагаар 14442А талбайн баруун хойд хэсэгт өмнөх онуудын ашиглалтаар үүссэн ухааш буюу хоосон орон зайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийгдэнэ. Шимт хөрсийг тусдаа овоолго болгон хадгална. 2 талбайн шимт хөрсний хэмжээ – 2500 м<sup>3</sup>

Төлөвлөгөөт онд MV-001441 тоот тусгай зөвшөөрлийн 0.36 га талбайд, MV-014442 тусгай зөвшөөрлийн 0.44 га талбайд тус тус дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөж байна. Нийтдээ 0.80 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийнэ.

Техникийн нөхөн сэргээлтийн зардлыг 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний үйлдвэрлэлийн зардалд оруулсан болно.

2024 онд биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй.

Тус компани “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд АМГТГазраас санал болгосон хувилбаруудаас “Тухайн онд эвдрэлд орсон талбайн 1 га тутамд 1000 мод” хувилбарыг сонгосон.

Энэхүү хувилбарын дагуу уурхайн аманд бургас төрлийн мод тарихаар төлөвлөж байна. 2024 онд олборлолтод өртөх талбайн хэмжээ 0.87 га болно. 0.87 га талбайг 0.9 га-гаар тооцож 900 ширхэг мод тарьж, арчлан хамгаалж ургуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт- 15. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө (техникийн, биологийн)

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Газрын гадаргыг анхдагч хэлбэрт оруулж, тэгшлэн биологийн нөхөн сэргээлтэд бэлэн болгоно.	Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт	га	0.80	2024 оны уулын ажлын төлөвлөгөөний үйлдвэрлэлийн зардалд оруулсан болно.		2024 он	"Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт" MNS 5917:2008  "Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5914 : 2008"
2	Биологийн нөхөн сэргээлт	-	-	-	-	-	2024 он	Төлөвлөөгүй

## **7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ил уурхайн олборлолтын явцад эвдэрсэн газрыг тухай бүрт нь нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал байдаг учраас түүний ойр орчмын нутаг дэвсгэрт тохиолдох, тухайн нутгийн экосистемд чухал үүрэгтэй, доройтож буй бүлгэмдэл болон популяцыг сэргээх, амьдрах орчныг сайжруулах хамгаалах зэрэг өөр бусад газруудад экосистемийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлийн ажлыг шат дараалан хэрэгжүүлэх боломжтой.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай. Ландшафтын төвшний төлөвлөлт буюу экологийн бүс нутгийн үнэлгээ нь нөлөөллийг бууруулах эдгээр алхмуудыг зохистой хэрэгжүүлэх үндэс болно.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох;
- Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох;
- Хэрэгжилтийн мониторинг хийх;
- Үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө гаргах.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах төрлийн байна. Үүнд:

- Биологийн олон янз байдлын шууд хамгааллын арга хэмжээ;
- Зүйл, бүлгэмдэл, экосистемийн аль нэг хүчин зүйлийг, сайжруулах, нөхөн сэргээх,
- Биологийн олон янз байдалд учирч буй аюул заналыг бууруулах;
- Амьдрах орчны холбогдох байдлыг сайжруулах гэх мэт.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санаачилгаар Монгол орны баруун бүсэд экологийн хувьд нэн ач холбогдолтой, зайлшгүй хамгаалах шаардлагатай газруудыг олон улсын байгууллагын тусламжтайгаар тогтоож, уг суурь судалгааны үндсэн дээр “Монгол орны баруун бүсэд дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төслийг хэрэгжүүлсэн.

Тус компанийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах талбайн 5 жилийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагын санал зөвлөмжийг тусган Шүтээн байгаль ХХК боловсруулсан. Энэхүү төлөвлөгөөг БОАЖЯ болон

аймгийн БОАЖГ-аар хянуулан, 2018-2022 онуудын хооронд буюу 5 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

2024 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Бөхмөрөн сумын нутаг дэвсгэрт хамаарах агнуурын бүс нутгуудад биотехникийн арга хэмжээ авна. Үүнд: 1000 кг давс, 30 боодол өвс бэлтгэж, зэрлэг амьтанд тавьж өгнө.

## НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхай 1963 онд анх нээгдэж үйл ажиллагаа явуулж эхэлсний дараа Хотгор тосгон бий болсон. Уурхайн эдэлбэр газарт оршин сууж буй айл өрх, өвөлжөөний хашаа байшин байхгүй учраас Нүүрст хотгорын уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөхгүй болно.

## 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Өнөөгийн байдлаар Бөхмөрөн суманд аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг жуулчны бааз байхгүй. Гэхдээ тус сум нь унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, эртний хүн чулуу, хөшөө дурсгал, хадны бичиг зэргийг агуулсан өвөрмөц тогтоц бүхий байгальтай, үндэстэн, ястны өвөрмөц ахуй, зан үйл, ан амьтан үзэж харах зэрэг нь дотоод гадаадын жуулчдыг татах ихээхэн нөөц боломж байна.

Уурхай 1963 оноос өнөөг хүртэл ажиллахдаа эдэлбэр газар болон уурхайн ойр орчимд Түүх, соёлын дурсгалт зүйл одоогоор илрээгүй болно.

Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу археологи, палеонтологийн олдвор шинээр илэрвэл газар шорооны ажлыг түр зогсоож аймаг, сумын удирдлага болон мэргэжлийн байгууллагад хандаж хамгаалах арга хэмжээг яаралтай авах болно.

Хүснэгт- 16. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Увс аймаг, Бөхмөрөн сум	Судалгаа хийх, төсөв гаргах	Ашиглалтын талбайн ойр орчимд			250.0	2024 он	-
	<b>Нийт</b>					<b>250.0</b>		

## 9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хотгор” ХХК нь нүүрсний уурхайг ил аргаар олборлолт хийхдээ тэсэлгээний ажилд энгийн тэсрэх бодис Анфо, өдөөгч 300 гр, тэсэлгээний хэрэгсэл: чочир дамжуулах шижим, цооногийн холбох хэрэгсэл, гадаргын холбох

хэрэгсэл, цахилгаан тэслүүр хэрэглэнэ. Эдгээр тэсрэх материалыг тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, өрөмдлөг-тэсэлгээний ажлын паспортыг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас”-аар олгодог. Тэсрэх материалыг Улаанбаатар хотын “МЕРА” ХХК, “Бласт” ХХК-иас гэрээгээр худалдан авна. Тэсрэх материалыг тусгай зөвшөөрөлтэй “Бласт Автомотив” ХХК, МЕРА ХХК-тай ачаа тээвэрлэлтийн гэрээ байгуулж хүргүүлнэ.

Газрын гадаргуйгаас хагас далдлагдсан, чулуу ханатай тэсрэх бодисын 24 тонн, тэсэлгээний хэрэгслийн 6 тоннын багтаамжтай байнгын 2 агуулахтай. Гэрээт харуул хамгаалалттай. Хяналтын 4 тооны теле камертэй.

Тэсрэх материалыг “Хотгор” ХХК-ийн нүүрсний уурхайн “Тэсрэх материалын зарцуулалтанд хяналт тавих журам”-ыг үндэслэн хатуу хяналтын дор олгоно. Тэсрэх бодисыг агуулахаас уурхайн талбайд хүргэхдээ зориулалтын зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр батлагдсан маршрутын дагуу тээвэрлэж хүргэнэ.



Хүснэгт- 17. Химийн бодисын эрсдлийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1.	Тэсрэх бодис	<p>Хотгорын ил уурхайн 2024 онд аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.</p> <p>Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах шилжүүлэн ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх</p> <p>Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл цэвэрлэгээний материал бэлтгэж бэлэн болгох</p> <p>Ашиглагдсан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав баглаа боодлыг орон нутгаас зааж өгсөн тодорхой талбайд булшлах, устгах эсвэл тусгай бэлдсэн вагончикт түр хадгалах арга хэмжээ авна.Аваарь ослын үед битүүмжлэл алдагдаж асгарсан болон тэсрэх бодис, нефтийн бүтээгдэхүүнийг (НБ) яаралтай хутган авч</p>	Уурхайн талбайн хэмжээнд			400.0	2024 он	<p>Галын аюулгүй байдлын тухай хууль, заалт 16.1, заалт 18.1, заалт 19.1, заалт 20.1, заалт 21.1</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль, заалт 4.2, заалт 2.10, заалт 6.1.2, зүйл 8; зүйл 9; заалт 10.1; зүйл 12; зүйл 14; заалт 15.1; заалт 16.1, заалт 16.2, заалт 16.3</p> <p>Геологи, эрдэс баялгийн судалгааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх галын аюулгүйн нэгдсэн дүрэм</p> <p>Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 14 дүгээр зүйл</p>

Нүүрст Хотгорын уурхайн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		савлаж, битүүмжлэх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээг яаралтай авах						
		Хоргүйжүүлж саармагжуулсан талбайг нөхөн сэргээх						
<b>Нийт дүн</b>						<b>400.0</b>		

## 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд уулын машин техникийн сольсон тосны шүүр, эд анги, дугуйнууд, аккумулятор, ашигласан тос, тэсрэх материалын сав, баглаа боодол зэрэг үйлдвэрийн гаралтай хог хаягдал мөн ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, хоолны газар, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн объектуудаас гарах хог хаягдлууд ордог болно.

Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд зааснаар иргэн, аж ахуйн нэгж нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно:

- Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
- Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
- Хог хаягдлыг ил задгай шатаах;
- Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
- Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
- Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.

### **Хог хаягдлын тодорхойлолт, ангилал**

Хуульд зааснаар “хог хаягдал” гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг хэлнэ. Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг дотор нь “энгийн хог хаягдал” ба “аюултай хог хаягдал”, “барилгын хог хаягдал” гэж ангилна.

Үүнд:

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ;
- Аюултай хог хаягдал гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг хэлнэ;
- Барилгын хог хаягдал гэж барилгын суурь бэлтгэх, барилга барих, засварлах, буулгах болон авто зам барих, засварлахад үүсэх хог хаягдал, явган хүний зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг;
- Хог хаягдлыг физик төлөвөөр нь доорх байдлаар ангилна. Үүнд:
  - Хатуу (хаягдал чулуулгаас бусад);
  - Шингэн (ахуйн болон үйлдвэрлэлийн хаягдал бохир ус);
  - Хий (тоосонцрууд, хөө тортог, үнэр г.м) зэрэг болно.

Байгаль орчны бүрдэл хэсгүүдэд хог хаягдал дараах байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй. Үүнд:

- Унаган төрхийг алдагдуулах;
- Хүлээн авч буй орчин (газар, агаар, гадаргын болон гүний ус г.м)-ыг бохирдуулах;
- Ургамал, амьтан хордуулах;
- Хэт мэдрэг хүлээн авагчдын эрүүл мэнд болон эрүүл ахуйг муутгах зэрэг болно.

Судалгаанаас үзэхэд уурхайд ажилладаг 1 хүнээс өдөрт дундажаар 1-1.5 кг хог хаягдал үүсдэг гэдгийг тооцвол Нүүрст хотгорын ордын хувьд өдөрт 52 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь 52-81 кг болж байна. Уурхайг 300 хоног ажиллуулна гэдгийг тооцвол жилд гарах ахуйн болон үйлдвэрийн гаралтай хатуу хог хаягдлын нийт хэмжээ нь 20 тн байна. Үүнийг Хотгор тосгоны төвлөрсөн хог хаягдлын цэгт зайлуулна.

Тосгоны оршин суугчид ундны болон ахуйн зориулалтаар ашиглах усыг Ямаатын голоос зориулалтын усны автомашинаар зөөвөрлөж ашиглана. Усны автомашин нь төрийн өмчийх. Өлгий сумын 7-р багийн оршин суугч нарын ундны усыг Ямаатын голоос тээвэрлэн хүргэж, оршин суугч нарт 1 литрийг нь 12 төгрөгөөр худалддаг. Уурхайн ажилчид мөн адил тэднээс худалдан авна. Харин компаниас 1 ажилтны ундны усны зардалд зориулан 1 сар тутам 15 000 төгрөг бэлнээр олгодог. Иймд орон нутагт төлөх ундны усны төлбөрийг ус тээвэрлэн худалдаг жолооч өөрөө хариуцан төлдөг.

Нүүрсний уурхайгаас гарах хатуу хог хаягдлыг хогийн төмөр саванд цуглуулж, Хотгор багийн төвлөрсөн хогийн цэгт зайлуулна. Уул уурхайн техникээс гарах хатуу хог хаягдал болох машин техникийн

сольсон эд анги, төмрийн хаягдал зэргийг засварын газрын ойролцоо тусгай талбайд цуглуулж байгаад хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт нийлүүлнэ.

**Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлууд:** Үүнд:

- Ашиглах боломжгүй болсон автомашины резин дугуйнуудыг тусгай талбайд хурааж, булж устгана.
- Ашигласан хаягдал тосыг төмөр торхонд цуглуулж түр хадгалж байгаад дахин боловсруулах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ.
- Тэсрэх материалын сав, баглаа боодлыг тусгай вагончид хадгалж, дараа нь устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ.
- Техникийн сольсон тосны, түлшний, агаарын шүүрнүүд, хуучин аккумуляторыг цуглуулж, тусгаарлан хадгалж байгаад устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ.

Түүнчлэн манай орны хувьд өнөө үед ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд хог хаягдлыг ангилан хоёрдогч түүхий эд материал болгон ашиглаж байгааг харгалзан түүнийг хэрэгжүүлэх боломжийг ч авч үзэх нь зүйтэй юм.

**Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын менежмент:**

Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Зайлуулах/устгах болон дахин ашиглах арга
Автомашины хуучин дугуйнууд	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Уурхайн засварын талбайн ойролцоо талбайд цуглуулж, хадгална. Цаашдаа талбайд булж устгана.
Ашигласан хаягдал тос	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Уурхайн талбай дээр цуглуулж, тусгай зөвшөөрөл бүхий хаягдал тос боловсруулах аж ахуйн нэгжид дахин боловсруулахаар хүргүүлнэ.
Хаягдал тосны савнууд	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Торхнуудыг дахин ашиглуулахаар бэлтгэн нийлүүлэгч рүү хүргүүлнэ.
Ашигласан тэсрэх материалын сав, баглаа боодол	Уурхайн хөрс, нүүрсний талбай	Талбайд тусгаарлан хадгалж, устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ.
Техникийн сольсон тосны, түлшний, агаарын шүүр, аккумулятор	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Талбайд тусгаарлан хадгалж, устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ.
Дахин боловсруулах боломжтой хог хаягдал. Тухайлбал: цаас, цаасан хайрцаг, хуванцар, шил, лааз г. м.	Уурхайн тосгон, захиргааны байр, ажлын талбай, засварын газар	Талбай дээр ангилан, цуглуулна. Дахин ашиглуулахаар тээвэрлэнэ.

Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн ажлын хэсгийн Хотгор ХХК-ийн төслийн талбайд хийсэн бохирдлын судалгааны тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлнэ.
2. Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай болно.
3. Аюултай хог хаягдлыг талбайд тусгаарлан хадгалж, дахин боловсруулах, устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлнэ. Гэрээ байгуулна.
4. Уурхайн дотоод болон гадаад орчны цэвэрлэгээг Байгаль орчны ажилтан хариуцан ажилладаг.
5. Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9а-д заасны дагуу аймгийн БОАЖГ-т албан бичгээр хүсэлт гаргаж, бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байгаа.
6. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, тусгаарлан тусгай байр, саванд хадгална.
7. Аюултай хог хаягдлыг төрөл төрлөөр нь хаягжуулна. Жич: Ашигласан тэсрэх материалын сав, баглаа боодол, хаягдал төмөр, ашиглагдахгүй хуучин дугуй, техникийн сольсон тос, түлш, агаарын шүүр гэх мэт. Мөн хуримтлуулж эхэлсэн хугацааг тусгай журналд тэмдэглэж байна.

### **Ажилчдын гуанз, уурхайн ажилчдын нүхэн жорлон барьж байгуулах**

Уурхайн эзэмшлийн талбайд нүхэн жорлон байгуулж ашиглахдаа “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага – MNS 5924:2008” стандартыг хангасан битүүмжлэл сайтай, ус нэвтрэхгүй бетон доторлогоотой тусгай бохирын цооног байгуулж ашиглана.

- Цооног нь ялаа, шавж орчихгүйгээр хийгдсэн байна. Цооногийн эзлэхүүнийг тооцоход хаях бохир усны хэмжээ, бохир усыг татаж зайлуулах хугацаа, гэнэтийн осол, аваарын үед гарах бохир усны хэмжээг харгалзана.
- Цооногийн орчны нөхцөлөөс хамааруулан эргэн тойрныг тэгшлэх, бороо, хурын ус чийг шүүрч нэвтрэхээс сэргийлэх, шаардлагатай бол хатуу хучилт хийнэ.
- Цооногийг бетоноор ус нэвчихгүй материалаар доторлоно. Доторлогооны зузаан нь цементийн марк (400-гаас доошгүй), бетоны марк, бэлтгэх технологи цооногийн гүн, эзлэхүүн, хөрсний усны байршлын гүнээс хамаарч 10 см-ээс багагүй байна.
- Цооногийн доторлогооны гадна талын хөрсний устай харьцах хэсгийг ус нэвтрэхгүйгээр хамгаалсан байна.

- Цооногийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед зориулалтын техник хэрэгслээр соруулж, тогтоосон цэгт зайлуулж хаяна.
- Цооногт хатуу хог хаягдал хаяхыг хориглоно.
- Цооног, түүний орчимд жил бүр тогтоосон хугацаанд хортон, шавжийн устгал хийнэ.
- Сум дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтан цооногийн ашиглалт, хэвийн найдвартай ажиллагааг жилд нэгээс доошгүй удаа шалгаж, цооногийн доторлогоо хагарч гэмтэн хөрс, усанд бохирдол үзүүлсэн тухай бүрд бохир ус хаяхыг нэн даруй зогсоох, цооногийг засварлуулах болон цаашид ашиглахыг бүрмөсөн хориглоно.

Хүснэгт- 18. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал,төг	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
2	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал	Хотгор тосгоны хог хаягдлын цэгт хүргэх	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал	тн	8333	36.0	300.0	Улиралд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль /2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр/
3	Хог хаягдлын арга хэмжээ	Хотгор багийн төвлөрсөн хогийн цэгийн хогийг ковшоор түрж хэлбэржүүлэн овоолох	Хотгор тосгоны хог хаягдлын цэг	га			900.0	2024 оны 5,10-р сард	
4	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал	Бөхмөрөн сумын ЗДТГазарт хогны төлбөр	-	-	-	-	500.0	2024 онд	
5	Нүхэн жорлон, угаадасны нүх	Хөрс хамгаалах зорилгоор стандартын цооног барьж байгуулах	Уурхайн талбай, захиргааны байр	-	-	-	2100.0	2024 онд	
6	Шаардлага хангасан хогийн сав, аюултай хог хаягдлыг хадгалах, хаягжуулах		Уурхайн талбай	га	-	90.45	1200.0	2024 онд	
	<b>Нийт дүн</b>						<b>5000.0</b>		

Жич: Аюултай хог хаягдлын талаархи авах арга хэмжээг химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан болно.





## **12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

### **12.1 Орчны болон ажлын байрны агаар орчны бохирдол код-Ю0**

#### **12.1.1 Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд**

Уурхай дахь агаарын тоосжилт

Уурхайн ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, доргио чичиргээ зэрэг физикийн бохирдлын түвшин, NO<sub>2</sub>, CO<sub>2</sub>, SO<sub>2</sub>, химийн зарим бодисын ууршилт зэрэг химийн бохирдлын түвшин)

#### **12.1.2 Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр**

Сорьц авах (тоосжилт)

Хэмжилт судалгаа хийх (тоосноос бусад)

#### **12.1.3 Хяналт шинжилгээ хийх сорьцыг авах цэгийн байршил**

Ил уурхайн агаарын найрлагыг тодорхойлох.

Уурхайчдын тосгоны агаарын фон бохирдолт. Нунтаг нүүрсийг шигшин ялгах чичиргээт тоног төхөөрөмжийн талбайн агаар орчинд хяналт шинжилгээ хийх.

#### **12.1.4 Хяналт шинжилгээний явуулах хугацаа, давтамж**

Жилд 2 удаа (5, 10 сард 3 цэгт)

#### **12.1.5 Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал**

MNS 3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага

MNS 0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ

MNS 3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ

MNS 5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO<sub>2</sub> тодорхойлох эзлэхүүний арга

MNS 0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга

MNS 0012-1-015:1987. Чимээ шуугиан-Ажлын байрны чимээ шуугианыг хэмжих арга

#### **12.1.6 Хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмж**

Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн багаж, тоног төхөөрөмж

#### **12.1.7 Үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт**

Хяналт шинжилгээний бүртгэл, тайланг эрх бүхий байгууллагаас баталсан маягтаар гаргана. Маягтыг дээр дурдсан лабораториас авна.

Хүснэгт- 19. Агаар орчинд хийх хяналт шинжилгээний хөтөлбөр

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Ажлын багтаамж	Зардал		Хугацаа он	Хариуцагч
		Нэгж, мян.төг	Бүгд, мян.төг		
Ил уурхайн агаарын найрлагыг тодорхойлох /Карьер/	Жилд 2 удаа	74	3 x 74= <b>222.0</b>	2024 он 5,10 сард	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан
Ашиглалтын талбайн гадна уурхайчдын тосгоны агаарын фон бохирдолтонд хяналт шинжилгээ хийх.	Жилд 2 удаа	74	3 x 74 = <b>222.0</b>	2024 он 5,10 сард	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан
Нунтаг нүүрсийг шигшин ялгах чичиргээт тоног төхөөрөмжийн талбайн агаар орчинд хяналт шинжилгээ хийх.	Жилд 2 удаа	74	2 x 74 = <b>148.0</b>	2024 он 5, 10 сард	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан
<b>ДҮН</b>			<b>592.0</b>		
Эдгээр хяналт шинжилгээг Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэнэ.					

**12.1.8 Мэдээлэл цуглуулах боловсруулах, үр дүнг тайлагнах**

Агаарын хяналт шинжилгээний үр дүнг лабораторын хэмжилт, шинжилгээний дүгнэлтийг үндэслэн гаргаж Увс аймгийн БОАЖГазар болон Бөхмөрөн сумын ЗДТГазарт жил бүрийн 11-р сарын 01-ны дотор, БОАЖЯамд жил бүрийн 12-р сарын 15-ны хүртэл тайлагнах болно.

**12.2. Хөрсний бохирдолд код-со**

**12.2.1 Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд**

Хөрсөн дэх макро, микро элементын үзүүлэлтүүд

Нефтийн бүтээгдэхүүний үзүүлэлтүүд

**12.2.2 Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр**

Сорьц авах

**12.2.3 Хяналт шинжилгээ хийх сорьцыг авах цэгийн байршил**

Олборлолт явагдаж байгаа талбай, уурхайчдын тосгон.

**12.2.4 Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж**

Жилд 1 удаа ( 5-р сард, 2 цэгт)

**12.2.5 Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал**

MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл

MNS 3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох

MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

### 12.2.6 Хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмж

Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн багаж, тоног төхөөрөмж

### 12.2.7 Үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт

Хяналт шинжилгээний бүртгэл, тайланг эрх бүхий байгууллагаас баталсан маягтаар гаргана. Маягтыг дээр дурдсан лабораториас авна.

Хүснэгт- 20. Хөрсөн бүрхэвчинд хийх хяналт шинжилгээний хөтөлбөр

Шинжилгээ хийх сорьцыг авах цэгийн байршил	Ажлын багтаамж	Зардал		Хугацаа он	Хариуцагч
		Нэгж, мян.төг	Бүгд, мян.төг		
Олборлолт явагдаж байгаа талбай	Жилд 1 удаа 1 цэгт	175.0	1 цэг x 1 удаа = <b>175.0</b>	2024 он 5 -р сард	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан
Ашиглалтын талбайн гадна хөрсний бохирдлын цар хүрээг тогтоолгох /Уурхайчдын тосгон/	Жилд 1 удаа 1 цэг	175.0	1 цэг x 1 удаа = <b>175.0</b>	2024 он 5 -р сард	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан
<b>ДҮН</b>			<b>350.0</b>		
Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжилгээ хийлгэнэ.					

### 12.3. Усан орчин бохирдол код-во

#### 12.3.1 Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд

- Ундны усны чанарын үндсэн үзүүлэлтүүд
- Нян судлалын үзүүлэлтүүд

#### 12.3.2 Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр

- Сорьц авах

#### 12.3.3 Хяналт шинжилгээ хийх сорьцыг авах цэгийн байршил

- Ямаат гол, Байрны голын ус

#### 12.3.4 Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж

- Унд ахуйн усанд - жилд 2 удаа, 1цэгт /Ямаатын гол/
- Байгаль орчныг хамгаалах зорилгоор хэрэглэх усанд –жилд 2 удаа, 1 цэгт /Байрны гол/

#### 12.3.5 Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал

- MNS 0900:1992 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ
- MNS 3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага
- MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх

### 12.3.6 Хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмж

Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн багаж, тоног төхөөрөмж

### 12.3.7 Үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгт

Хяналт шинжилгээний бүртгэл, тайланг эрх бүхий байгууллагаас баталсан маягтаар гаргана. Маягтыг дээр дурдсан лабораториас авна.

Хүснэгт- 21. Усан орчинд хийх хяналт шинжилгээний хөтөлбөр

Шинжилгээ хийх сорьцыг авах цэгийн байршил	Ажлын багтаамж	Зардал		Хугацаа он	Хариуцагч
		Нэгж, мян.төг	Бүгд, мян.төг		
Ундны зориулалтаар ашиглаж буй усанд /Ямаатын гол/ болон байгаль орчныг хамгаалахад хэрэглэх усанд /Байрны гол/ жилд 2 удаа Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжилгээ хийлгэнэ.	Жилд 2 удаа	112.0	2 цэг х 2 удаа х 100.0 = <b>400.0</b>	2024 он 5,10 сард	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан

Хүснэгт- 22. Байгаль орчныг хамгаалах жил бүрийн мониторингийн ажлын хэмжээ, холбогдох зардал

№	Ажлын төрөл нэр	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Нийт зардал мян.төг
1	Мэргэжилтнүүдийн хоногийн ажиллах цалин	Хүн /өдөр			
2	Буудлын зардал	Хүн/хоног			
3	Томилолтын зардал	Хүн/хоног			
4	Тээврийн зардал	км			
5	Шинжилгээний зардал	Агаар	2 удаа 3 цэгт	98.6	<b>592.0</b>
		Хөрс	1 удаа 2 цэгт	175	<b>350.0</b>
		Усан орчин	2 удаа 2 цэгт	100	<b>400.0</b>
<b>Дүн /Жилд/</b>					<b>1342.0 мян.төг</b>

Хүснэгт- 23. Нүүрст хотгорын уурхайд 2024 онд хийгдэх монитронгийн шинжилгээ дээж авах талбайн координат

Дээж авах талбай	Координат	Хариуцагч
Агаар орчин	90° 53' 51.5", 49° 50' 57.21"	Уурхайн дарга
Хөрс, ургамлын орчин	90° 53' 56.57", 49° 50' 58.01"	Уурхайн дарга
Усан орчин	90° 53' 55.97", 49° 50' 56.8"	Уурхайн дарга

### **13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг үйлдвэрлэлийн ерөнхий инженер хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх бөгөөд нөхөн сэргээлт хийж дууссан талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэж өгнө.

Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл зэргийг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, тайлагнаж байх.

Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1-2 удаа сургаж, дадлагажуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана.

Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгах.

Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

### **14. ДОТООД ОВООЛГОД ШАТАЛТ ҮҮССЭН НӨХЦӨЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сүүлийн жилүүдэд Хотгорын нүүрсний уурхайн техникийн нөхөн сэргээлт хийсэн дотоод овоолгод исэлдэлт явагдаж, стандартын шаардлага хангахгүй хаягдсан чулуулаг нүүрс, шавар, чулуу хэвийн нөхцөлд байхад үе үе утаа гарч заримдаа өөрөө шатах тохиолдолд гараад байна.

Компанийн зүгээс утаа гарч шатах илрэл гарч эхлэнгүүт бүх хүн хүч, машин техникийг дайчлан ажиллаж байгаа ба энэхүү үйл ажиллагаанд жилд 200 000 000 ₮ дээш хэмжээний үргүй зардал гарч санхүүгийн хүндрэл учирахаас гадна орчны агаарыг зохих хэмжээгээр бохирдуулах эрсдэлтэй.

Утаа уугиж шатаж байгаа хэсгийг ачиж аюулгүй талбайд зөөвөрлөх эсвэл элс хайрга бүхий хөрсөөр дарж унтраах зэрэг арга хэрэглэж байсан.

2021 оны 12-р сарын эхээр Монголын Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлд шинжээчин дүгнэлт гаргуулахаар хүсэлт тавьж, 2021 оны 12-р сарын 30-ны өдөр “Сэцэн Болор Өргөө” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан.

Монгол улсын зөвлөх инженер Ж.Бат тэргүүтэй мэргэжлийн хүмүүс уурхайд ирж ажиллаж, уурхайн галыг унтраах ажлын тайлан боловсруулж, утаа

уугиж шатаж буй дотоод овоолго, асч буй галыг 4 - 8 %-ийн шохойн уусмалаар унтраах аргыг зөвлөмж болгосон юм.

Уурхайн дотоод овоолгод шатлага явагдаж, утаа уугиж шатах үед “Мөнхийн-Оргил” ХХК-ийн боловсруулсан “Нүүрст хотгорын уурхайд гарсан галыг унтраах ажлын тайлан”-гийн зөвлөмжийн дагуу ажиллана. ОБЕГазрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн 2022 оны 03-р сарын 21-ний өдрийн санал дүгнэлтийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Мөн дотоод овоогод шатлага гарсан зарим тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Шатаж буй голомтыг ачиж аюулгүй талбайд зөөвөрлөх.
2. Шатлага явагдаж байгаа талбайг элс хайрга бүхий хөрсөөр зузаан дарж вакуум орчин үүсгэж шатлагын голомтыг зогсоох.
3. Дотоод овоолгод утаа үүсэх үед нь экскаватор ашиглан бусад хэсгээс тасалснаар /таслан унтраах/ цаашид утаа уугиж тархан дэлгэрэх нөхцөлийг хязгаарлана.

Шатлага явагдаж, утаа уугиж байгаа голомтыг зөөвөрлөх, элсээр дарах, таслан унтраах ажилд экскаватор, өөрөө буулгагч автомашин, авто ачигч зэрэг уул уурхайн техникийг ашиглана. Шатаж байгаа голомтыг ачиж зөөвөрлөхөд ил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахиж, голомтод ажиллаж байгаа ажиллагсдад хамгаалах хэрэгсэл олгоно.

Талбайд ажиллаж байгаа ажиллагсдын аюулгүй байдлыг хангах, угаартахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. Голомтод ажиллах ажилчдад халуун хоол, хор саармагжуулах сүү, хамгаалах хэрэгслүүдийг тухай бүр олгоно.

Уурхайн өөрөө шаталтын голомтыг өдөр бүр шалгаж, шалгалтын мөрөөр тухай бүр арга хэмжээ авч ажиллах болно.

**Дотоод овоолго** гэдэг нь олборлолтод өртсөн, нүүрсний нөөц нь дууссан хоосон талбайг хөрс хуулалтаас гарсан хөрс, чулуулаг, стандартын шаардлага хангахгүй исэлдсэн, шавар чулуу холилдсон хаягдал нүүрс зэргээр дүүргэлт хийж, булж тэгшлэх аргаар техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай.

Хүснэгт- 24. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
	1	2	3	4	5	6	7
1	Нийт уурхайчдыг байгаль орчныг хамгаалах сургалтанд хамруулах	300.0				Уурхайн дарга	

2	Орон нутгийн иргэдэд уурхайн үйл ажиллагааг сурталчилж таниулах	200.0				Уурхайн дарга	
3	Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх	Дотоод зохион байгуулалтаар				Гүйцэтгэх захирал	
4	Тэсэлгээний паспорт хөдлөх	Дотоод зохион байгуулалтаар				Ерөнхий инженер	
<b>Нийт</b>		<b>500.0</b>					

**Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Ажлын төрөл	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Хяналт тавих албан тушаалтан
1	Уулын ажлыг АМГТГазрын Уул уурхайн хэлтсээр батлуулсан төлөвлөгөөний дагуу явуулах	Жилийн турш	Уурхайн дарга М.Аманкелди Талбайн мастер А.Аскерхан	Гүйцэтгэх захирал З.Кадирхан
2	Аймгийн БОАЖГ-тай 2024 онд Ус ашиглах гэрээ байгуулна	2024 оны 02-р сард	Гүйцэтгэх захирал З.Кадирхан	
3	Хуурайшилттай үед уурхайн дотоод тээврийн замыг чийглэх	2024 оны 5 - 9 сарын хооронд	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
4	Уурхайн дотоод овоолгод шаталтын голомт үүссэн нөхцөлд мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу шатлагын голомтыг унтраах арга хэмжээг тухай бүр авч ажиллах	Жилийн турш	Байгал орчны ажилтан Т.Жумахан Талбайн мастер А.Аскерхан	Уурхайн дарга М.Аманкелди
5	Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, амны хаалт, дуу чимээ ихтэй газарт ажилладаг ажиллагсдыг чихэвчээр хангах	Жилийн турш	ХАБЭА ажилтан Н.Ардах	Уурхайн дарга М.Аманкелди



6	Увс аймгийн УЦУОШТ-тэй байгуулсан гэрээний дагуу агаар, хөрс, усны шинжилгээг хийлгэх	2024 оны 5, 10-р сар	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Гүйцэтгэх захирал 3.Кадирхан
7	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийх	2024 оны 4, 5, 6,7,8 сард	Уурхайн дарга М.Аманкелди	Гүйцэтгэх захирал 3.Кадирхан
8	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 900 ширхэг бургас мод тарьж, арчлан хамгаалах, ургуулах	5 сард	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Гүйцэтгэх захирал 3.Кадирхан
9	Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажил зохион байгуулах	Жилийн турш	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
10	Байрны горхи сайр дагуу хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах	2024 оны 5-р сард	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
11	Хотгор тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэгийн хогийг дугуйт ачигчаар түрж хэлбэржүүлэн, овоолох.	2024 оны 5, 10-р сард	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
12	Борооны ус, үерийн хамгаалалтын шуудууг сэргээж цэвэрлэх	5-р сард	Талбайн мастер А.Аскерхан	Уурхайн дарга М.Аманкелди
13	Тээврийн жолооч нар нь олон салаа зам гаргахгүй байх, зөвхөн нэг замаар зорчуулах зорилгоор замын 2 талд татсан 18 км урттай шуудууг сэргээж цэвэрлэх. Тээврийн хэрэгсэл нь замыг сэтэлж гарсан тохиолдолд шуудууг дахин ухаж сэргээх, далан босгох	5-р сард	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
14	Уурхайн мэдээллийн тэмдэг, тэмдэглэгээг хийлгэж байршуулах Уурхайн дотоод тээврийн замын анхааруулах, хориглох тэмдэг, тэмдэглэгээний заримыг шинэчлэх.	5-р сард	ХАБЭА ажилтан Н.Ардах	Уурхайн дарга М.Аманкелди
15	Зэрлэг амьтадын шилжилт хөдөлгөөнд ажиглалт, судалгаа хийх	Жилийн 4 улиралд	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди

## **15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болно.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт- 25. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Багийн ИНХ	ИНХ-д илтгэл тавьж, мэдээлэл өгөх	-	Жилд 1 удаа	Дотоод зохион байгуулалтаар	Уурхайн удирдлага, БО-ны мэргэжилтэн	Хар-алтад багийн төвд
2	Засаг даргын Тамгын газар	Төслийн байгаль хамгааллын ажлын талаар мэдээлэл өгөх	-		Дотоод зохион байгуулалтаар		Бөхмөрөн сумын иргэний танхим
3	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид	Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар мэдээллэх	-		Дотоод зохион байгуулалтаар		Хар-алтад багийн төвд

4	Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Хэрэгжилтийг тайлагнах	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл		Дотоод зохион байгуулалтаар		Увс аймгийн иргэний танхим
5	БОАЖЯам	Хэрэгжилтийг тайлагнах	Тухайн оны БО-ны менежментийн төлөвлөгөөг батлуулах		Дотоод зохион байгуулалтаар		БОАЖЯ-нд ХБОБНУГ-т

Хүснэгт- 26. “Хотгор” ХХК-ийн Нүүрст хотгорын уурхайн **2024** оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хийгдэх ажлын зардлын товчоо

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл	Нийт зардал. мян.төг
1.	Агаарын орчныг хамгаалах	4900.0
2.	Усан орчныг хамгаалах	990.0
3.	Хөрс, ургамал, амьтан хамгаалах	4130.0
4	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах тусгай төлөвлөгөөгөөр хэрэгжүүлнэ
5	Түүх, соёлын өв хамгаалах	250.0
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	400.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4900.0
8	Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
9	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200.0
10	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1342.0
<b>Нийт дүн</b>		<b>17612.0</b>